

Г.Цэнд-Аюуш

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш

Улс төрийн шинжлэх ухааны арга зүйн зарим асуудал

Өгүүллийн товч утга: Өнөөгийн Монголын нийгэмд өрнөж буй өөрчлөлт шинэчлэлийн үед улс төрийн бодлогын олон асуудлууд жил жилээ дагаж гарч ирлээ. Ийм нөхцөлд монголын олон нийтэд улс төрийн шинжлэх ухааны үүрэг ач холбогдол онцгой нелөөтэй билээ. Энэхүү өгүүлэлд улс төрийн шинжлэх ухааны үндсэн ойлголтуудыг тайлбарлан судлах зүйл хамрах хүрээг тодруулахыг эрмэлзэв.

Түлхүүр үг. Улс төрийн систем, засаглал, улс төрийн институт, улс төрийн маркетинг, имижмейкер, консенсус

Манай оронд 1990-ээд оноос өрнөсөн ардчилсан үйл явцын үр дүнд нийгмийн амьдралын бүхийл хүрээг хамарсан өөрчлөлт шинэчлэлтийн бодлого өрнөж байна. Ардчилал шинэчлэлтийн зам монгол түмний сонгож авсан улс төр, эдийн засгийн зорилго, дэлхийн нийтийн хөгжлийн түүхэн хандлагын салшгүй хэсэг болох тул энэхүү эргэж буцашгүй сонголт иргэдийн нийгэм улс төрийн идэвхи, ухамсар мэдлэгийн төлөвшилт хөгжлийн асуудлыг тойрч өнгөрөх бололцоогүй нь тодорхой билээ.

Нөгөөтэйгүүр энэхүү төвөг бэрхшээлтэй түүхэн хандлага иргэдийн улс төрийн боловсрол соёлоос үлэмж хэмжээгээр шалтгаалах нь мэдээжийн хэрэг юм. Ийм хөдөлмөрчдөд түүний дотор насны байдал, тооны хувьд харьцангуй тогтвортой нийгэм улс төрийн идэвхитэй бүлэг болсон оюутан залуучуудад (40мян. орчим) улс төрийн мэдлэг соёл төлөвшүүлэх асуудал нийгмийн ухааны түүний дотор улс төрийн шинжлэх ухааны нэгэн зорилго болж байгаа юм.¹

Нийгмийг юуны өмнө залуучуудын тусламжтайгаар нэлэнхүйд нь өөрчлөх нь чухал “өнөөгийн залуу үе түүхийн эргэлтийн үед төржээ. Тэдний асуудал өмнөх бүх үеүдийн нэгнийх нь ч асуудалтай огт төсгүй юм”². Үүнээс үүдэн улс төрийн шинжлэх ухааны олон асуудал өнөөгийн шинэчлэлийн байр сууринаас хандах арга аргачлалыг ашиглах шаардлага гарч байна. Ингэж өгүүлсний нэгэн учир нь Монгол оронд 80 гаруй жил коммунист үзэл нийгмийн ухамсарын суурь үзэл болж түүнд үндэслэгдсэн ангийн болон коммунист үзэл суртал хүн амын ухамсарт ноёрхох болсон байна. Учир иймээс монголчуудын хэдхэн жилийн өмнөх хуучин сэтгэлгээгээ шинэчлэлийн үзэл санааны дагуу дэлхий нийтэд өрнөж буй өөрчлөлт шинэчлэлийн үйл явцтай уялдуулан ухаан бодлоо шинэчлэх шаардлага урган гарч байна. Энэ бол яштал баримталсан үзэл суртлаа эргэж харан түүндээ шүүмжлэлтэй хандана гэсэн үг юм.³

Орчин үеийн нийгэмд улс төртэй хамааралгүй хүн гэж нэг ч байхгүй, хүн өөрөө улс төрийт сонирхдоггүй, тэр надад хамаагүй гэж боддог байлаа ч гэсэн түүнийг аж төрөхөд эд хөрөнгө, мэдээлэл, нийгмийн халамж хамгаалал, амьдралын баталгаа, нийгмийн байр суурь гэх мэт үнэт зүйлс зайлшгүй шаардлагатай.

Гэтэл эдгээр үнэт зүйлс нь улс төрийн системийн үйл ажиллагааны үр дүнд л хуваарилагддаг болохоор ямарч хүн улс төрийн нөлөөллөөс зайлсхийх боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Түүнчлэн засаг, эрх мэдлийн төлөө тэмүүлэл хүний мөн чанарт өгөгдсөн байдаг гэж үздэг ч судлаачид бий. Л.Гумплович 1902 онд бичсэн “ Социологи” номондоо хүнд хэрэгцээгээ хангах хоёр хэрэгсэл байдаг. Эхнийх нь хөдөлмөр эрхлэх явдал: удаах нь бусдын хөдөлмөрийг ашиглах, бусдыг албадах явдал гэжээ. Нэгдэх нь эдийн засгийн хэрэгсэл,

¹ Монголын эдийн засаг, нийгэм статистикийн эмхтгэл УБ., 1997.

² Х.Батсаа, С.Даш Орчин үе, дэвшилт залуучуудын хөдөлгөөн. УБ., 1978, 70-р тал.

³ Б. Даш-ёндон, “Сэтгэлгээгээ шинэчлэх хямралаас гарч дэвшихийн үндэс” Бодрол бясалгал сэтгүүл УБ., 1993. 1-2

хоёрдахь нь улс төрийн хэрэгсэл. Энэ улс төрийн хэрэгсэл зохион байгуулагдсан нөхцөлд төр үүссэн юм гэж тэрээр үзжээ.¹

Одоогоос 2500 гаруй жилийн тэртээ эртний грекийн гүн ухаантан Аристотель "хүн бол улс төрийн амьтан" гэж тэмдэглэсэн байдаг. Ер нь хувь хүний улс төрийн шинж нь түүний нийгэмшлийн үр дүнд бүрэлдэх бөгөөд ихэнхи судлаачдын үзэж байгаагаар энэхүү нийгэмшил нь хүний амьдралын бүхий л үеийн турш явагддаг гэжээ.

Иргэний улс төрийн нийгэмшил гэж хувь хүний нийгмийн улс төрийн соёлыг эзэмшин тодорхой дүр бүтээх чадварыг хэлнэ. Улс төрийн нийгэмшлийн эцсийн бүтээгдэхүүн, үр дүн нь хувь хүний улс төрийн систем, төр засагтаа хандах тодорхой хандлага, улс төрд оролцох чадвараар тодорхойлогдоно. Ер нь нийгэмшил улс төрийн соёл хоорондоо залшгүй уялдаатай бөгөөд улс төрийн соёл нь нийт нийгмийн улс төрийн үйл байдлыг илэрхийлэх бөгөөд хувь түүнийг хүн тусган авч нийгэмшдэг.

Бие хүний нийгэмшил, улс төрийн үйл байдлыг түүний улс төрийн итгэл үнэмшил тодорхойлоно. Бие хүний улс төрийн итгэл үнэмшил бол төр нийгэм, эрх чөлөө, шударга ёс, тэгш эрх зэрэг улс төрийн гол гол асуудлаар хамгийн үнэн шударга гэж үзэгдэх үзэл бодлын систем юм. Энэхүү системийн суурь нь хүмүүсийн улс төрийн мэдлэг, боловсрол, ухамсар байдаг. Ийм мэдлэг ухамсартай болсноор хүн улс төрийн олон асуултанд хариулт өгөх чадвар олж авахын зэрэгцээ тэр нь бие хүний улс төрийн итгэл үнэмшлийн танин мэдэхүйн талыг тусгадаг болно. Хүн улс төрийн аливаа үзэгдэл, үйл явдалд сэтгэл хөдлөлийн үүднээс хандах түүнийг сайшаах, дэмжих, эсэргүүцэх дургүйцэх зэрэг байдал гаргадаг бөгөөд үүнийг улс төрийн итгэл үнэмшлийн сэтгэл хөдлөлийн тал гэнэ. Нөгөөтэйгүүр хүн улс төрийн үзэгдлийн талаарх мэдлэг, сэтгэл хөдлөлийн байдалдаа үндэслэн уг үзэгдлийг сайн муу, зөв буруу гэх юм уу эсвэл уг үзэгдлийн мөн чанар буй болсон шалтгаан хэтийн төлөвийн талаар дүгнэлт хийхийг оролддог. Энэ нь улс төрийн нийгэмшлийн үнэлгээний талыг харуулдаг юм.

Социализмын үед нийгмийн шинжлэх ухаан тухайн үед эрх барьж байсан МАХН-ын туйлширсэн үзэл суртал, түүнд хшигдсан улс төрийн бодлого үйл ажиллагааны "хамгаалах хэрэгсэл" болон ашиглагдаж байв. Иймээс нийгмийн шинжлэх ухааны хямралын үндсийг шинжлэх ухаанаас эрж хайх ёсгүй. (учир нь шинжлэх ухаан үнэнийг эрж хайхыг эрмэлздэг) харин тухайн үеийн улс төрийн тогтолцооны гажуудлаас эрж хайх ёстой нь тодорхой билээ. Гагцхүү 1990-ээд оны ардчиллын үйл явцын эхлэл шинжлэх ухаанууд, түүний дотор нийгмийн шинжлэх ухаан үзэл суртал, улс төрийн бодлогын хүлээнээс чөлөөлөгдөн хөгжих таатай нөхцөл бүрэлдэх эхлэлийг тавив. Тиймээс "нийгмийн шинжлэх ухааны асуудалд хамгийн бат найдвартай үнэхээр зөв ханддаг дадлагатай болохын тулд, үй олон жижиг зүйл буюу харилцан тэмцэлдэгч олон янзын саналд оролцохгүйн тулд... хамгийн чухал нь түүх үндсэн холбоо хэлхээг мартахгүй байх, зохих үзэгдэл түүхэнд хэрхэн үүссэн, хөгжилдөө ямар ямар гол үе шат туулж өнгөрсөн... тэр үзэгдэл одоо чухам ямар болов гэдгийн үүднээс асуудлыг авч үзэх"² хэрэгтэй гэсэн методологийг үндэс болгов.

Бие хүний улс төрийн нийгэмшилтэд нөлөөлдөг чухал субъектуудын нэг нь их, дээд сургуулиуд юм. 1991 онд Шинжлэх ухаан боловсролын яамны (хуучнаар) сайдын тушаал гарч улс төр судлалын хичээлийг их, дээд сургуулиудад албан ёсны сургалт болгож заах шийдвэр гарсан билээ. 1993 оноос Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн дэргэд улс төр судлалын салбар

¹ Г.Цэнд-Аюуш Монголын нийгэмдэх өөрчлөлт шинэчлэлт ба өнөөгийн залуучууд. ТИС.ЭШБ 1992.

² В. И. Ленин 29-р боть 467-р тал

ангийг нээж, улс төрийн шинжлэх ухааны анхны мэргэжилтнүүдийг бэлтгэх ажил эхэлсэн. Энэ мэргэжлийн ангид улс төрийн мэдлэгийг системтэй эзэмшүүлэх чиглэлээр олон тооны тодорхой хичээлүүд заагдаж байгаагийн дотор орчин үеийн өрнөдийн улс төрийн шинжлэх ухааны үндсэн чиглэл хандлага гэсэн хичээл чухал байр суурь эзэлнэ. Иймд улс төрийн шинжлэх ухааны суурь ойлголт, ухагдахууныг уламжлалт ойлголттойгоо харьцуулан үзэх шаардлага гарч байна. Энэ талаар өөрийн байр суурь санал бодлоо хуваалцах зорилго тавьсан юм.

1. Нэрийн тухай: Ерөнхий улс төрийн шинжлэх ухаан улс төрийн бодлогыг түлхүү судладаг. Энэ утгаар нь үзвэл улс төрийн систем, байгууллага газрыг судладаг ухаан. Тиймээс эрт үеэс эхлэн янз бүрийн орнуудад уг шинжлэх ухааныг янз бүрээр нэрлэж ирсэн.

Жишээ нь: Францад улс төрийн социологи, Испанид политологи, Англид улс төрийн судалгаа, АНУ-д улс төрийн шинжлэх ухаан, Орост улс төрийн шинжлэх ухаанууд, Японд улс төр судлал харин Монголд улс төр судлал хэмээн одоогоор нэрийдэж байна. Ингэж нэрлэж байгаа явлууд хоёр зүйлтэй холбоотой.

а) Улс төрийн шинжлэх ухааныг нийгмийн бусад шинжлэх ухаануудтай (түүх, философи, социологи, сэтгэл зүй, эдийн засаг, газар зүй гэх мэт) хослуулсан байдлаар судлах явдлыг зорилгоо болгосонтой холбоотой. Учир нь уламжлалт үед улс төрийн шинжлэх ухаан дээрхи шинжлэх ухаануудын уулзвар зааг дээр хөгжиж ирсэн билээ.

б) Улс төрийн шинжлэх ухаан бие даасан хими, физик лугаа адил тодорхой шинжлэх ухаан байх ёстой гэсэн үүднээс нэрлэсэн. 1948 онд Парис хотноо болсон Олон улсын политологчидын чуулга уулзалтаас улс төрийн шинжлэх ухааны судлах зүйлийн хүрээ хязгаарыг тоймлож, түүнийг албан ёсны бие даасан шинжлэх ухаан мөн гэж зарласан билээ.

2. Улс төрийн шинжлэх ухааны судлах зүйлийн тухай: (предметийн) Улс төрийн шинжлэх ухаан- улс төрийн бодлогын тухай шинжлэх ухаан. Зарим орнуудад улс төрийн шинжлэх ухааныг судлах тодорхой зүйлийн талаар янз бүрийн санаа, баримтлалууд байдаг.

Жишээ нь: Францын эрдэмтэн М.Дюверже “Улс төрийн шинжлэх ухаан бол засаглалын тухай шинжлэх ухаан гэж үзсэн. Яагаад гэвэл улс төрийн шинжлэх ухаан улс төрийн засаглалтай шууд холбоотой асуудлыг сүдалдаг. Улс төрийн засаглалыг улс төрийн системийн институтууд хэрэгжүүлдэг гэж тэрээр үзжээ.

Гэтэл өнөө үед улс төрийн бодлогын онолыг зөвхөн улс төрийн засаглалын асуудлын хүрээгээр хязгаарлаж болохгүй нь нэгээнт тодорхой боллоо. Тиймээс улс төрийн шинжлэх ухааны судлах зүйлийн хүрээ нийтийн сайн сайхны баталгааг хангах, шударга ёсны, хүний эрх, эрх чөлөөний, нийгмийн халамж хамгааллын, хүн ба байгаль орчны зохистой харьцааны гэх мэт хүмүүнлэгийн асуудлуудаар өргөжин тэлсээр байна.

Тиймээс шинэ тутам хөгжиж байгаа тогтвортой хэвшин тогтносон энэ улс төрийн шинжлэх ухааны уламжлал багатай Монгол орны нөхцөлд энэ шинжлэх ухааны судлах зүйлийг тодотгох нэр томъёо, тайлбарыг нэг мөр тогтоож хэвшүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Бас монголд эхлэн өрнөж байгаа ардчилсан үйл явцыг дагаад нийгмийн амьдралын бүх хүрээнд тэр дундаа улс төрийн хүрээнд (бусдаасаа илүү гэж хэлж болно) өөрчлөлт хувьсалт өрнөж, сонгуулийн ардчилсан системийн загвар бий болж, иргэдийн улс төрийн оролцоо дээшилсэн гэх мэт олон нааштай өөрчлөлтүүд бий болсныг харгалзан үзвэл зохилтой.

Мөн хажуугаар нь хүндрэл бэрхшээлүүд, гажуудал бий болсон. Энэ бүхнийг улс төрийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, баталж нотлох шаардлага гарч ирж байна. Тиймээс өнөөгийн нийгэмд гарч байгаа улс төрийн

бүтцийн шинэ чиглэлүүд, тэдгээрийн хоорондын харилцаа холбоог судалж эргэцүүлэн шинжлэх явцад улс төрийн шинжлэх ухаанд шинэ шинэ чиглэлийг дагасан салбар ухаанууд бий болж байна. Энэ бол жам ёсны үйл явц юм. Иймд өнөөгийн нөхцөлд улс төрийн шинжлэх ухааныг цогц байдлаар, өөрөөр хэлбэл бусад шинжлэх ухаануудтай холбогдуулж судлах, мөн бие даасан тодорхой чиг хандлагаар яаж судлах вэ? гэсэн асуудал бидний тулгамдсан зорилго болж байна.

Ингээд улс төрийн шинжлэх ухааны судлах зүйлийг дээрх байдалтай холбогдуулан дараах байдлаар тодруулж үзэх санаа байна.

А. улс төрийн болон түүнтэй шууд холбоотой нийгмийн системүүдийн бүтэц, бүрдэл төлөвшлийг дагнаж судлах явдал.

Б. Засаглал, удирдлагын систем, улс төрийн авторитетийн үүсэл хөгжлийн асуудлыг судлах. Засаглал улс төрийн бодлог хоёр хоорондоо салшгүй холбоотой. Тиймээс засаглалын бүтцэд, мөн засаглалыг хэрэгжүүлж ашиглах механизмд төр, иргэд ямар байр суурьтай байх вэ? гэдэг асуудал.

В. Тухайн улс төрийн системийн тогтвортой байдлыг хангах механизм, улс төрийн хямрал, нийгмийн мөргөлдөөний үүсэл шалтгаан, үйл явц, үр дагаварыг нээж илэрүүлэх, бас тэдгээрийг зохицуулах механизм улс төрийн практик туршлагыг судлах.

Г. Улс төрийн шинжлэх ухаанаар хүмүүст (ажиглагч, шинжээч, судлаач, улс төрийн бодлоготон) нийгэмд болж байгаа улс төрийн үзэгдэл, үйл явц, бодит байдлын талаар системтэй, өргөн дэлгэр үнэн зөв, мэдлэг мэдээлэл хүргэх. Дээрх судлах зүйлийн зорилтуудаасаа хамаараад улс төрийн шинжлэх ухааны категори, ойлголтуудыг нягтлах, тодпорхойлох нэг мөр болгож хэвшүүлэх шаардлага тавигдаж байна. Ер нь аль ч шинжлэх ухаан өөрийн гэсэн категори, ойлголтын системтэй байдаг ба тэдгээрээр дамжуулж сургах, судлах практик хэрэгцээгээ хангадаг. Гэтэл шинэ тутам хөгжиж байгаа улс төрийн шинжлэх ухаанд энэ тал дээр хүндрэл бэрхшээл тохиолддог.

Юуны өмнө тухайн оронд тус шинжлэх ухаан аль хэр боловсрогдон хөгжиж байв, түүний ойлголтын аппаратууд нь хэр зэрэг цэгцэрч боловсрогдсон зэрэгээсээ хамааран харилцан адилгүй байдаг. Энэ тал дээр Монголчууд бидэнд олон бэрхшээл байна. Наад зах нь бусад шинжлэх ухаануудаас зээлдсэн нэр томъёо энэ шинжлэх ухаанд олон бий. Мөн гадаад орнуудаас урьд нь манайд хэрэглэгдэж байгаагүй шинэ шинэ нэр томъёо, ойлголтууд орж ирлээ. Жишээ нь: Консенсус, легитим, улс төрийн менежмент, улс төрийн маркетинг, элитарность, имиждмекер, гэх мэт

3. Улс төрийн шинжлэх ухаан бол нийгмийн олон шинжлэх ухаануудын уулзвар зааг дээр үүсэж бүрэлдэж ирсэн. Үүнд: социологи, шашин, сэтгэл судлал гэх мэт. Иймээс зарим нэр томъёог янз янзын утга агуулагтайгаар хэрэглэгдэж байна. Жишээ нь: Засаглал, эрх мэдэл, ноёрхол, нөлөөлөл, электрат эдгээрийг нэг мөр болгох асуудал маш чухал.

Мөн байгалийн шинжлэх ухаанаас олон нэр томъёо, ойлголтууд орж ирсэн. Үүнд: математик, физик, биологи, магадлалын онол, геологи, тоглоомын дүрэм. Энэ бүхнээс үүдээд өнөөдөр манайд нэр томъёо, ойлголтуудын системд нягтлах товлох асуудлууд баагүй гарч ирсээр байна. Жишээ нь: Институт- эрх шинжлэх ухаанаас орж ирсэн ба эрх зүйчид үүнийг эрх зүйн хэм хэмжээ, зүйн шинжлэх ухаанаас орж ирсэн ба эрх зүйчид үүнийг эрх зүйн хэм хэмжээ, хууль эрхийн актууд, тэдгээрийг хэрэгжүүлж байдаг байгууллага газруудыг хамааруулж үздэг. Зарим тохиолдолд улс төрийн үзэл суртлуудыг ч хамааруулдаг. Иймээс улс төрийн нэр томъёоны тайлбар толь гаргах шаардлага тавигдаж байна.

4. Улс төрийн шинжлэх ухааны бүтцийн талаар дурьдъя:

Гадны материалуудыг хараад байхад хоёр үндсэн хэсгээс бүрдэж байна.

1. улс төрийн ерөнхий онол, баримтлалууд
2. хавсарга улс төр судлал

- I. 1. Улс төрийн шинжлэх ухааны судлах зүйл, аргууд
 2. Улс төрийн онол (теоритическая политология)
 3. Улс төрийн систем ба иргэний нийгмийн дүн шинжилгээ
 4. Иргэдийн нийгэм-улс төрийн идэвхи оролцоо, олон нийтийн санаа бодол
 5. Улс төрийн нам, байгууллага хөдөлгөөн
 6. Улс төрийн болон нийгмийн институтуудын роль
 7. Хүн амын нийгмийн халамж хамгааллын институтууд төрийн бус байгууллага
- II.
1. улс төрийн онол ба улс төрийн практик
2. засаглалын системүүдийн бүрдэлт, төлөвшлийн асуудал (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх)
3. орон нутгийн өөрийгөө удирдах ёсны бүрдэлт
4. төлөөллийн бүтцүүд дэх комисс, хороод
5. ул төрийн намуудын фракци
- III. Улс төрийн үйл явцыг судлах, дэлхийн хэмжээгээр
Бус нутгийн
Орон судлал
- IV. Мөргөлдөөн судлал
- V. Улс төрийн үзэл санаа, үзэл баримтлалуудын түүх, орчин үеийн улс төрийн школуудыг судлах.

Оюутан залуус нийгмийн томоохон бүлэг хэсэг болохынхoo хувьд нийгмийн улс төрийн амьдралд оролцох тэдний оролцоо нь улам бүр өсч байна. Олон ургальч үзэл хөгжиж ардчилал ил тод байдлын давалгаа өрнөж байгаа өнөө үед оюутан залуусын улс төрийн ухамсарын түвшин хандлагыг тэдний өөрийн ухамсарын суурь дээр чиглэсэн зорилготой төлөвшүүлэхэд их, дээд сургуулиудад заагдаж байгаа нийгмийн ухааны сургалтын систем онцгой ач холбогдолтой болж байна.

Нийгмийн ухааны сургалтын явцад тэдний нийгэм улс төрийн ухамсар үйл байдлын идэвхижилт, өсөлтөд үр нөлөөгөө өгөхүйц бодит байдлын олон талт үзэгдэл юмсыг шинжлэх ухаанчаар танин мэдэх, төр улс төрийн намуудын дэвшүүлсэн зорилт эдийн засгийн бодит арга хэмжээг үнэлэх тодорхой үнэлэмжтэй болгох зорилго хэрэгжиж байх ёстой. Их, дээд сургуулиуд дахь нийгмийн шинжлэх ухааны хичээл Монгол улсын түүхийн хичээлээр эхэлдэг.

1. монголын түүх бол оюутан залуусын үндэсний болон иргэний ухамсарт чанарыг төлөвшүүлэх, тэдэнд түүхэн үзэгдлийн учир холбогдлын шалтгааныг илрүүлэн дүгнэх үндсэн дээр нийгмийн хөгжлийн зүй тогтлыг танин мэдэх онолын бэлтгэл суурийг тавьдаг юм.
2. Философийн шинжлэх ухааны үүрэг бол ертөнцийг танин мэдэх диалектик аргыг эзэмшиүүлэх, энэ үндсэн дээр нийгэм-улс төрийн үзэл санаа байр сууриа тодорхойлох цэгцтэй системийг төлөвшүүлэх явдалд онцгой ач холбогдолтой.
3. Улс орон зах зээл, чөлөөт өрсөлдөөний хөгжлийн хандлагад татагдан орж байгаа нь тэднээс нийгмийн үзэгдлүүдийн эдийн засгийн үндсийг ойлгох, улмаар аж ахуй удирдлагын үйл явцын үр ашигтай хэлбэр, механизмыг боловсронгуй болгож оролцох явдлыг зүй ёсоор шаардана. Иймд эдийн засгийн онолын хичээлийн үүрэг өссөөр байх болно.
4. Улс төрийн шинжлэх ухаан оюутан залууст төр нийгэм, иргэдийн хоорондын зохистой тогтолцоог ойлгох улс төрийн системийн хөгжлийн зүй тогтлыг энэ зүй тогтолд, иргэн хүний, эрх үүрэг, эрх чөлөө, чөлөөт байдлыг олж ухамсарлах бололцоог олгох зорилт тавьдгаараа онцлогтой юм.

Ийнхүү их, дээд сургуульд заагдаж буй нийгмийн шинжлэх ухаанууд оюутан залуусын нийгэм-улс төрийн боловсрол, хүмүүжил, ухамсар соёлын төлөвшилтэд зохих нэлээстэй төдийгүй, их дээд сургууль дахь сургалт хүмүүжлийн үйл ажиллагааны гол чиглэл болж өрнөх нь дамжиггүй.

Ишлэл татсан, ашигласан ном, материал

1. Монголын эдийн засаг, нийгэм статистикийн эмхтгэл УБ., 1997.
2. Х.Батсаа, С.Даш Орчин үе, дэвшилт залуучуудын хөдөлгөөн. УБ., 1978
3. Б.Даш-ёндон, "Сэтгэлгээгээ шинэчлэх хямралаас гарч дэвшихийн үндэс" Бодрол бясалгаль сэтгүүл УБ., 1993.
4. Г.Цэнд-Аюуш Монголын нийгэмдэх өөрчлөлт шинэчлэлт ба өнөөгийн залуучууд. ТИС. ЭШБ 1992.
5. В. И. Ленин 29-р боть 467-р тал